


Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Есүс шуургыг
намдаасан нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest

Найруулсан: Ruth Klassen


Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2016 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**





Есүс болон түүний дагалдагч нар завин дээр байх үед хүчтэй шуурга ирэв. Шуурга хүчтэйгээр Галил тэнгисийг ташуурдав. Энэ төрлийн шуурганд завь живж болох байлаа.



**Шуурганаас болж дагалдагч нар айдаст автжээ.
Далайн давлагаа завийг бүрхэж уусаар дүүргэв.
Харин Есүс энэ шуурганд унтаж байлаа. Дагалдагч**


**нар Есүсийг
сэрээхээр
“Багшаа
Багшаа
бид
үхэх нь”
ХЭМЭЭН
хашхирав.**




“Та нар юунд ингэтлээ айна вэ итгэл багатай хүмүүсээ?” Хэмээн Есүс дагалдагч нараасаа асуулаа. Тэгээд Есүс салхинд намдахыг тушаав ... бас Есүс шуурганд намж чимээгүй бол хэмээн тушаав.



Салхи намдаж ... тэнгис нам гүм болов.




Дагалдагч нар “Энэ хүн хэн болоод салхи тэнгис хүртэл түүнд захирагддаг билээ” хэмээн шивнэлдэж байв.



**Хэд хоногийн дараа, Есүс бас л завгүй байлаа.
Бараг 5000 орчим хүн Түүнийг цөлөрхөг
нутаг хүртэл дагаж иржээ. Бурханы
хүчээр Есүс бүх хүнийг нэгэн бяцхан
хүүгийн өдрийн хоолоор бүх
хүнийг хооллосон юм.
Орой болж Есүс
хүмүүсийг
явуулав.**



Дагалдагч нар ч явцгаав. Есүс тэднийг завин дээр суулгаад Галил тэнгисийн нөгөө эрэг уруу өөрийнхөө өмнө явуулав.





**Тэр хурсан олныг
явуулсны дараа
ганцаараа
залбирахаар уул
өөд гарав. Орой
болоход Тэр тэнд
ганцаараа
байлаа.**





Нууранд дагалдагчид
салхинд туугдан
байв. Тэд
хэдийгээр
сэлүүрдэж
байсан
ч салхи
тэднийг
эргээс
холдуулж
байв.





Дагалдагч
нар энэ явдал
тэдэнд маш том
гэнэтийн бэлэг
барина гэж
бодоогүй
байлаа.





**Үүрийн гурваас
зургаан цагийн
хооронд нуурын
дунд ямар нэг юм
байгааг дагалдагч
нар хараад тэд
айдаст автаж “Энэ
хий үзэгдэл байна!”
хэмээн тэд
хашхиралдав.**





Харин тэр бол
тэдний Эзэн Есүс
байсан бөгөөд
тэднийг чиглэн
усан дээгүүр
алхаж байв.



“Зоригтой бай!”
хэмээн Есүс тэдэнд
хэлэв. **“Би байна бүү**
ай” гэв. **Петр Түүнд**
“Эзэн хэрэв Та мөн
юм бол усан дээгүүр
алхаж Өөр уруу
тань ирэхийг надад
тушаагаач” гэв.
Есүс **“Ир”** гэлээ.
Петр зоригтойгоор
завинаасаа гарч усан
дээргүүр алхан Есүс
уруу явав.





**Харин Петр
салхи хараад
айн живж эхлэв.
Тэгээд “Эзэн,
намайг авраач
гэж орилов.”**



Есүс тэр даруй гараа сунган, түүнийг зууран “Бага итгэлт минь, чи юунд эргэлзэнэ вэ?” гэж асуув. Тэгээд Петр болон Эзэн Есүс хоёрыг завинд гарахад салхи зогсов.



Завин дээр байсан
хүмүүс Есүст мөргөж
“Та бол үнэхээр
Бурханы Хүү мөн”
гэцгээв.



Есүс шуургыг намдаасан нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Матай 8, Матай 14, Марк 4, Лук8

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

